



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/403

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг
сунгаж, зарим арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 259 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 35 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Спорт заал, усан бассейн, фитнес, баар, караоке, сүм хийдийн үйл ажиллагааг 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 30 хувийн дүүргэлттэйгээр халдварт, хамгааллын дэглэм баримтлан ажиллахыг зөвшөөрсүгэй.

3. Дээрх байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100858